

# БОЛОВСРОЛЫН ХҮРЭЭЛЭН ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙН СУДАЛГААНЫ ТӨВ

Хүүхэд, залуусын хөгжлийн туршилтын  
судалгааны зарим үр дүн

“Монгол туургатан хүүхдийн  
хөгжил” олон улсын эрдэм  
шинжилгээний хуралд



# Оршил

- Нийгмийн хувьсан өөрчлөгдөж буй шилжилт өөрчлөлтөөс үүдэн өнөөгийн хүүхэд залуусын бие махбодь, сэтгэл зүй, нийгэмшлийн байдал хориод жилийн өмнөхтэй харьцуулахад ихээхэн өөрчлөгдөж буй талаар бид хэлэлцсээр байна.
- Хүүхэд залуусынхаа хөгжлийг улс орнууд тодорхой хэмжээнд судлан, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлсон байдаг ба тэдгээрийн холбоо хамаарал нь тухайн орны хүүхэд залуусын амжилттай иргэн болон төлөвшихөд ихээхэн нөлөөлдөг болохыг улс орнуудын судалгааны үр дүнгүүд харуулж байна.



# Судалгааны үндэслэл

- Танин мэдэхүйн процесс нь хүн юмсын мөн чанар, учир шалтгааныг ойлгохын үндэс юм.
- Танин мэдэхүй нь сурах үйл ажиллагаатай холбоотой.
- Танин мэдэхүйн процессууд нь бие даасан өвөрмөц үйл ажиллагаатай хэдий ч харилцан бие биетэйгээ нөхцөлдсөн нэгдмэл шинжийг агуулна.
- Танин мэдэхүй нь хүний бие бялдар, сэтгэл хөдлөл, харилцааны хөгжилтэй салшгүй холбоотой. Жишээ нь: бие бялдын хөгжил нь танин мэдэхүйн хөгжлийн өсөлт болон нийгмийн харилцааны чадварт нөлөөлдөг байна (McDevitt & Ormrod, 2004)
- Танин мэдэхүйн хөгжлийн шалгуур нь сэтгэхүйн бие даасан шинж, сургалтын материалын эзэмшилтийн хурд, асуудлыг шийдвэрлэх хурд, оновчтой байдал, аливаа зүйлсийн гол ба гол бус шинжийг ялгах чадвар, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, ерөнхийлөх чадвар, сэтгэхүйн шүүмжлэлт чанар, юмсыг дөт хялбараар сэтгэх чадвар зэрэг болно.



- Нийгэмшихүй- сэтгэл хөдлөлийн хөгжлийн хэмжигдэхүүн нь өөрийн сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах, зорилгодоо хүрэх, бусдын сэтгэлийг ойлгох, бусадтай эерэг харилцааг хадгалж үлдэх болон хариуцлагатай шийдвэр гаргах зорилгоор аливаа мэдлэг, хандлага, ур чадвар зэргийг өөрийн болгон түүнийг үр дүнтэй амьдралдаа хэвшүүлэх үйл явцын нэгдэл юм. (Collaborative for Academic, Social and Emotional Learning, 2013) CASEL нийгэмшихүйн хөгжлийг дотор нь доорх дэд хэсгүүдэд авч үздэг байна.
1. Нийгмийн чадамж /Social Skills/
  2. Сэтгэлийн хөдөлгөөний чадамж /Responsible Decision making/
  3. Өөрийн ухамсар /Self awareness/
  4. Ээнэгшилт /Relationship skills/
  5. Бие хүний зан төлөв /Self management/





Бид хүний нийгэмшлийг авч үздэг шалгуурт шинжилгээ хийж, дараах шалгууруудын давхцалыг үндэслэн Монгол хүүхдийн нийгэмшихүйн хөгжлийг судлахад авч үзэж болох юм гэж үзлээ. Үүнд:

1. Харилцааны чадамж
2. Нийгмийн дасан зохицол
3. Үнэт зүйл ба хэм хэмжээ
4. Бие хүний онцлог
5. Өөрийн ухамсар
6. Сэтгэлийн хөдөлгөөний чадамж
7. Ээнэгшилт



- Бид энэ удаа дасан зохицох чадвар, харилцааны хөгжил, сэтгэлийн хөдөлгөөний чадамж, өөрийн ухамсрын чадамжийг судалсан судалгааны дүнг та бүхэнд танилцуулахыг зорилоо.



- Хүүхдийн өсөлт хөгжилтөд эрүүл мэндийн байдал, хооллолт чухал үүрэг гүйцэтгэдэг. *Хөгжингүй орны хүүхдийн биеийн өсөлт сайн байгааг судалгааны дүн харуулж байна (Джи & Чен, 2008). Харин амьдралын түвшин доогуур, бага орлоготой, муухан хооллодог хүүхдийн биеийн өсөлт удаашрах,, хатингарших, жижигрэх өвчний хандлага илэрч байна (Barnes-Иосию & Augustin, 1995; Cole, 2000).* Олон улс орны хүмүүсийн биеийн, өсөлтийн хэмжээ зогсонги байдалд орж харин биеийн жин, биеийн жингийн индексийн үзүүлэлт өсч байна. АНУ болон Бельги, Чех, Герман, Унгар гэх мэт Европын хэд хэдэн оронд таргалалтын асуудал хурцаар илэрч байна ( Karlowitz, 2008; . Parents and etc., 2003 ).
- Таргалалтыг тодорхойлох хамгийн энгийн арга нь биеийн жингийн индексийг тогтоох юм.



# Зорилго

- Монголын хүүхэд, залуусын цогц хөгжлийг судлах үндсэн зорилгын хүрээнд Монголын хүүхэд, залуусын нийгэмшихүйн хөгжлийг судлах, хөгжлийн шалгуур, үзүүлэлт боловсруулахад оршино.





# Судалгааны объект

- 6-21 насны хүүхэд, залуусын танин мэдэхүй, нийгэмшихүй, бие бялдрын хөгжил



# СОРИЛЫН НАЙДВАРТАЙ ЧАНАР

- Сорилын найдвартай чанар буюу reliability нь Cronbach's Alpha гэдэг статистик үзүүлэлтээр тодорхойлсон.
- Бидний сорилын найдвартай чанар танин мэдэхүйн сорил 0.718, нийгэмшлийнх 0.85 гарсан тул танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг сорил даалгаврууд тодорхойлж чадсан гэж үзлээ.



# Ажигч чанар

6-7 насанд юмсыг хурдан хугацаанд ажиглан таньж, бүхэл бүтнээр хүртэх чадвар доогуур байна.

(M=2.3)


8-21 нас хүртэлх хүүхэд, залуусын ажигч чанар дундаж хэвийн түвшинд байна. (M=3.1)

## 6-7 насны хүүхдийн ажигч чанар



6 нас

7 нас




# Анхаарлын тогтворжилт

- Анхаарлын тогтворжилт нь оюуны ажиллах чадварыг илэрхийлдэг тул сурах чадварын маш чухал шалгуур үзүүлэлт болдог.
- Судалгаанд хамрагдсан өсвөр, ахлах анги, оюутан насны хүүхэд залуусын анхаарлын тогтворжилтын дундаж үзүүлэлт нь хангалттай сайн түвшинтэй нь харагдлаа. (M=4.3) Арван дөрвөн насанд буурсан үр дүн харагдлаа.





# Анхаарлын тогтворжилт




# Ой тогтоолтын онцлог

- Ой тогтоолтыг богино хугацааны харааны ой, сонорын ой, утгын ой тогтоолтын хүрээнд судаллаа.
- Судалгаанд хамрагдсан нийт сургуулийн бага 8-9 нас, өсвөр, дунд, ахлах, оюутан насны богино хугацааны харааны ой дундаж хэвийн түвшинд ( $M=2.8$ ) байна.




# Богино хугацааны харааны ой тогтоолт



# Сонорын ой тогтоолт

Сонорын ой тогтоолтын хувьд нийт судалгаанд хамрагдагсад дундаж түвшинтэй.  
(av.5>3.3)






# УТГЫН ОЙ ТОГТООЛТ


- Утгын ой тогтоолтыг богино хэмжээний өгүүллэг уншин, утгыг нь яриулах аргаар судаллаа.
- Судалгаанд хамрагдсан өсвөр, ахлах, оюутан насны хүүхэд залуусын хөгжлийн дундаж үзүүлэлт дундаж түвшинд байна. (M=2.9)
- 6-7 нас, 18-19 насанд мэдээллийг утгачлан тогтоох чадвар сайн үзүүлэлттэй байна.




# УТГЫН ОЙ ТОГТООЛТ



# 6-7 настны сэтгэхүйн хөгжил



# Хийсвэр сэтгэхүйн хөгжил






# Хэл яриа ба сэтгэхүйн холбоо

- Бид хэл яриа ба сэтгэхүйн холбоог судлахдаа ухагдахууны төлөвшил, идэвхгүй үгийн нөөц буюу үгийн утгыг танин нийтлэг шинжээр нь харьцуулах чадвараар тодорхойлсон.




# Ухагдахуун төлөвшил



- Сурагч, оюутны үгийн утгыг ойлгон тодорхойлох чадвар дундаж түвшинд байна. (M=2.7)
- Өсвөр бага насанд доогуур түвшинд, 13 наснаас нэмэгдсэн байна. 21 насанд хангалттай сайн байна.
- Хорин нэгэн насны залуус үгийн утгыг тодорхойлох чадвар сайтай байгаа нь үгийн нөөц илүү байгаагийн илэрхийлэл болно.



# Идэвхгүй үгийн нөөц





- Тухайн чадвар нь 6-13 насанд хангалтгүй доогуур түвшинд байна. 14-16 насанд аажим нэмэгдсэн байна. Харин 17 насанд бага зэрэг буурч, 18-21 насанд харьцангуй сайжирчээ.
- Оюутнуудын талаас илүү хувь нь үгсийн утгын ойлголт, хооронд нь харьцуулан төстэй нийтлэг шинжийг олох чадвар 18-20 насанд сайн байдаг байна.



# Дүгнэлт


- Хэдийгээр судалгааны аргуудын тохироцыг авч үзэх зорилготой туршилтын судалгааны зарим үр дүнг авч үзэж байгаа ч хүүхэд, залуучуудын хөгжлийн үзүүлэлтүүдээс дараах дүр зураг харагдаж байгааг дүгнэв. Үүнд:
- Судалгаанд хамрагдсан хүүхэд залуусын сэтгэхүйн хөгжил хангалтгүй үр дүнтэй байсан тул бид цаашид үндсэн судалгаандаа арга зүйн тал дээр анхаарах хэрэгтэй байж болох юм.



- Ой тогтоолт ой хэвийн дундаж үзүүлэлттэй байв.
- Анхаарлын төвлөрөл хангалттай сайн түвшинтэй байна.
- Суралцагчдын хэл яриа, үгийн нөөцийг нь нэмэгдүүлэх, үгийн утгыг ойлгох, гол шинжид нь үндэслэн утгыг тодорхойлох, өргөн хүрээний ахуйн бус үгс, нэр томъёоны талаар мэдлэг эзэмших, үгийн утгын ялгаатай болон төсөөтэй талыг олдог байх логик чадвар нь танин мэдэхүйн хөгжлийн чухал шалгуур үзүүлэлт тул энэ талын мэдлэг, чадвар, туршлага эзэмшүүлэхийг чухалчлах хэрэгтэй.




# Харилцааны хөгжлийн онцлог



Судалгааны үр дүнгээс харахад, нийт 6-21 насны судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын бусадтай харилцах хамтран ажиллах чадвар илүү сайн төлөвшсөн байна. Бусдаас дэмжлэг авах чадвар арай доогуур түвшинд байна.



# Харилцааны хөгжлийн онцлог насаар







# Сэтгэлийн хөдөлгөөний чадамж




# Сэтгэлийн хөдөлгөөний чадамж нас бүрээр



# Дасан зохицох чадвар



# Дасан зохицох чадвар нас бүрээр




- Насны хувьд авч үзвэл, дасан зохицох чадвар нь өсвөр нас болох 11-13 насанд илүү сайн байна. Энэ нь тэдний харилцааны хөгжил, нас зүйн онцлогтой уялдаатай.
- Нийт судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын дасан зохицох чадвар хэвийн байна. Ялангуяа, хариуцлагатай зан, асуудалд бодитоор хандах, бие даан шийдвэр гаргах, зорилгын төлөө биеэ дайчлах, амжилтанд тэмүүлэх чадвар, бусдыг хүндэтгэн найрсаг нөхөрсөг хандах, найз нөхөд болох чадвар илүү байна.
- Бусдыг хошуучлан манлайлах эрмэлзэл дундаас доогуур түвшинд харагдаж байна.






# Өөрийн ухамсарын хөгжил




# Өөрийн ухамсарын хөгжил нас бүрээр



# Дүгнэлт

- Хэдийгээр судалгааны аргуудын тохироцыг авч үзэх зорилготой туршилтын судалгааны зарим үр дүнг авч үзэж байгаа ч хүүхэд, залуучуудын хөгжлийн үзүүлэлтүүдээс дараах дүр зураг харагдаж байгааг дүгнэв. Үүнд:
- Хүүхэд, залуучуудын нийгэмшлийн чухал үе нь бага ангид 7 нас, дунд ангид 11-12 нас, ахлах ангид 16 нас, оюутан насанд 18-20 нас байна.
- Бүх шатны суралцагчдын хувьд анхаарах бие хүний чадвар нь харилцааны чадамж юм. Ялангуяа, бусдаас дэмжлэг тусалцаа хүсэх, мэдээлэл асуух идэвхтэй зан үйл, харилцааны үед өөрийн зан төлөвөө нөхцөл байдалд тохируулан хянан зохицуулах чадвар байна.



- Өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг хянах, нөхцөл байдалд тохируулан сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг гаргах, сөрөг сэтгэлийн хөдөлгөөн, сэтгэл догдлолоо дарах чадвар хангалтгүй байна.
- Суралцагчид хэдийгээр өөрийн гадаад байдал, дүр төрх, зан ааш, байр суурь мэдлэг, чадвараа хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч өөртөө итгэх итгэл доогуур байгаа нь тэдний өөрийн идэвхжилт, санаачилгатай зан үйлд сөргөөр нөлөөлөх бүрэн боломжтой юм.



# Бие бялдарын хөгжил


Бид та бүхэнд энэ удаа хүүхэд залуусын бие бялдар, биеийн жингийн индексийг танилцуулж байна.






# Хүүхэд залуусын биеийн жин, өндөр

## Биеийн жин



## Биеийн өндөр




6-7 нас    8-10 нас    11-14 нас    15-16 нас    17-21 нас

6-7 нас    8-10 нас    11-14 нас    15-16 нас    17-21 нас



# Биеийн жингийн индекс



# Дүгнэлт

- Биеийн жингийн индекс нь 6-21 насны хүүхэд залууст хэвийн үзүүлэлттэй байгаа нь таргалалт, тураалгүй байгааг илэрхийлнэ.
- Насны хувьд өндөр, жингийн огцом өсөлт ажигдлагдсангүй, харьцангуй жигд өөрчлөлттэй байв.
- Судалгаанд хамрагдсан хүүхэд залуусын хувьд бусад настай харьцуулахад 8-10 насанд харьцангуй өндөр байна.
- Биеийн жин бусад настай харьцуулахад 15-16 насанд бага зэрэг илүү нэмэгдсэн тал ажиглагдлаа.



# Анхаарал хандуулсанд баярлалаа

